



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 1/89

Амардалай

Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан  
Сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
Зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-9,8 дахь заалтууд, УИХ-ын түр хорооны 2023 оны 01 дүгээр сарын 11 өдрийн 02 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 1 ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл ХХААХҮЯ-ын сайдын 2023 оны А/02 дугаар тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2023 оны 05 дугаар сарын 19 ний А/125 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/366 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 06 сарын 06 ний өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд 2023 оны 06 сарын 06 ний өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд бог малын мялзан өвчнөөс урьдчилсан сэргийлэх нэгдсэн дархлаажуулалтын зар мэдээг малчид, мал бүхий иргэдэд хүргэх, зорилтот мал сүргийг бүрэн хамруулан ажлыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Наранцэцэг ( МЭТ-ийн дарга )

Гишүүд: М.Даваацэрэн ( Дэлгэрбаяндалай МЭҮН -ийн эмч)

Э.Дэлгэрмаа (Дэлгэрбаяндалай МЭҮН -ийн эмч )

Н.Балданжав ( Арвин тэгш баялаг МЭҮН-ийн эмч )

Б.Довуучий ( 1-р багийн Засаг дарга )

Г.Сосорбурам ( 2-р багийн Засаг дарга )

Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга )

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг батлагдсан хуваарийн дагуу технологит хугацаанд нь зохион байгуулж

ажиллахыг баг тус бүрд ажиллах малын эмч Д.Наранцэцэг, М.Даваацэрэн, Н.Балданжав нар даалгасугай.

4.Вакцины дархлаа бүрэн тогтох хүртэл малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийг 21 хоногийн хугацаанд хориглосугай.

5.Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйгээр ханган, тарилгын технологит гүйцэтгэл, мал эмнэлгийн нэгдсэн системийн гүйцэтгэлд хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг тайлагнан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Наранцэцэг) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

